



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 дугаар сарын 17 өдөр

Дугаар 37

Хэрлэн сум

ХХХVII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 37 дугаар хуралдаан 2021 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 17:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 84,0 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.БОЭТ-ийн Халдвартын тасагт хяналтын камер суурилуулах талаар мэдээлэл танилцуулах,

Тагнуулын газар

2.Сум хооронд зорчиж байгаа иргэн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах талаар хэлэлцэх

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

3.Хөлөнбуйр, Цагаан-Овоо суманд бүх төрлийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох талаар хэлэлцэх

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

4.Хаан, Голомт, Төрийн банкны Дорнод салбаруудаас ирүүлсэн тусгай горимоор ажиллах тухай хүсэлтийг хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

5.Иргэний нийгмийн байгууллага, хөршийн холбооны идэвхитэн гишүүдийн гаргасан хүсэлтийн дагуу гэрийн тусгаарлалтад хяналт тавих талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

6.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичиг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн, хурандаа Б.Бямбаа-д:

1.1.БОЭТ-ын Халдвартын тасгийн хяналтын камер байршуулах 2 ширхэг шон суурилуулах зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

/М.Бадамсүрэн

/Д.Баттулга

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

2.1.Аймгийн Шуурхай штабыг бүлгийн зохион байгуулалтад оруулах, бүлгүүдийн ажиллах хуваарь, бүтцийг боловсруулж танилцуулах,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

2.2.Аймгийн Шуурхай штабын өрөө, тасалгааг нэмэгдүүлэх, албан хаагчдын ажиллах орчинг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Хөлөнбуйр, Цагаан-Овоо суманд бүх төрлийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай аймгийн Онцгой комиссын тогтоол батлуулах,



Дөрөв.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

4.1.Хаан, Голомт, Төрийн банкны Дорнод салбаруудаас ирүүлсэн тусгай горимоор ажиллах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол батлуулах,

Тав.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,
Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

5.1.Иргэний нийгмийн байгууллага, хөршийн холбооны идэвхитэн гишүүдийн гаргасан хүсэлтийн дагуу гэрийн тусгаарлалтад хяналт тавих ажлыг зохион байгуулах,

Зургаа.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Цагаан-Овоо сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга Д.Батмагнай нарт:

/  /М.Бадамсүрэн
/  /Д.Баттулга

6.1.Иргэн С.Б-ийн аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу Цагаан-Овоо сумын Засаг дарга, сумын Онцгой комиссын хяналтан дор иргэн Д.Б-г, 12 тооны адуутай нэвтрүүлдэхийг зөвшөөрөв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА ДЭД ХУРАНДАА 346 Д.БАТТУЛГА

